



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

Т О Г Т О О Л

1960 оны 2 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар
хот

Зарим авто аж ахуйг нэгтгэх
ба шинээр байгуулах тухай.

Улаанбаатар хотын олон тооны автобаз, гараж нь нэгдсэн удирдлагагүй, тархай бутархай, засварын үзлэг, ашиглалтын тодорхой график төлөвлөгөөгүй үйлчилж байгааг төвлөрүүлэн нэгтгэж, үйлчилгээг сайжруулах зорилгоор Б.Н.М.А. Улсын Сайд нарын Зөвлөлөөс **Т О Г Т О О Х** нь:

1. Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргааны харьяанд одоо ажиллаж байгаа олон тооны жижиг автобаз, гаражийг 1960 оны 3 дугаар сарын 1-ний дотор нэгтгэж, дор дурдсан хоёр авто баз болгон төвлөрүүлэхийг Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргаа/н.БАТАА/-д зөвшөөрсүгэй:

а/Хотын худалдаа, нийтийн хоолны трестүүдийн автобаз;

б/хотын нийгэм хангамжийн үйлчилгээний автобаз.

2. Богинын тээврийн автобазыг 1960 оны 2 дугаар сарын 15-ны дотор Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргааны шууд харьяанд байгуулсугай.

Үүнтэй холбогдуулан, дор дурдсан арга хэмжээ авсугай:

а/энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдсан 56 автомашиныг богинын тээврийн автобазад сэлбэг хэрэгсэлийн хамт балансаас балансад шилжүүлсүгэй;

автобазын

2.

б/богийн тээврийн авто машины хөлсний тарифыг автомашин-даац, ачааны бардал, газрын хол ойрын хэмжээнд тохируулан, түүгээрээ батлаж гаргахыг хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргаанд зөвшөөрсүгэй;

в/богийн тээврийн барад зориулан, 1960 онд эхний хагас жилд 50 машины гаражийг Улаанбаатар хотын барилга-контороор бариулж, түүнд шаардагдах хөрөнгийг Тээвэр, Холбооны Яамны автобазуудын даргын мэдлийн ба элэгдэл хорогдлын 40%-ийн фондын 1959 оны үлдэгдлээс гаргахыг Сангийн Яам/н. ДУГЭРСҮРЭН/, Тээвэр, Холбооны Яам/н. ДАМДИНЖАВ/, Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргаа/н. БАТАА / нарт даалгасугай;

г/хотын сургууль, цэцэрлэг, яслыг, хороо, хорьдны захиргаад, хотын чанартай эмнэлгийн газруудаас богийн тээврийн автомашин хөлсийг төлөхдөө зөвхөн ачаатай явсан тонн км/дугам бодож байхаар тогтоосугай.

✓ 3. Хотын авто аж ахуйнуудыг төвлөрүүлэн нэгтгэж байгаатай холбогдуулан, Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргаанд 4 хүний орон тоотой тээврийн хэлтсийг 2-р хавсралт ёсоор 1960 оны 3 дугаар сарын 1-ний дотор байгуулсугай.

4. Хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргаанд шинээр байгуулагдах тээврийн хэлтэс ба автобазуудад шаардагдах мэрэгжлийн хүмүүсээр хангахыг Тээвэр, Холбооны Яам/н. ДАМДИНЖАВ/-т даалгасугай.

Б.Н.М.А. Улсын Сайд нарын
Зөвлөлийн 1-р орлогч дарга
Б.Н.М.А. Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг эрхлэх
газрын 1-р орлогч дарга

МОЛОМЖАМЦ

ЦЭРЭНЖАВ

Хуулбар үнэн; Тогтоол ангийн

эрхлэгч

ПАГВАЦОРЖ

Сайд нарын Зөвлөлийн 1960...
оны 54 дүгээр тогтоолын 1-р
хавсралт.

Богинын тээврийн базад шилжүүлэх автомашинны
тодорхойлолт

Автомашинны марк	: Автомашин шилжүүлэх газар : машинны			
	: Тээвэр, : хотын		: хотын сургууль, : тоо	
	: Холбоо- : эмнэлэг, : нэцгэрлэг		:	
	: ны Яам : яслы		:	
1:.,ЗИЛ-164"	27	-	1	28
2:.,ГАЗ-51 "	4	6	9	19
3:.,ГАЗ-АА "	-	-	2	2
4:.,ЗИС-5 "	-	2	5	7
Дүн	31	8	17	56

Сайд нарын Зөвлөлийн
1960 оны 54-дүгээр
тогтоолын 2-р хавсралт

Хотын гүйцэтгэх захиргааны тээврийн хэлтсийн
орон тоо, цалингийн фонд.

№: Албан тушаалын нэр	:орон:сарын цалин-:сарын		:сарын
	:тоо	:гийн хэмжээ	:цалин-
			:гийн
			:фонд
1:Хэлтсийн дарга бөгөөд инженер	1	825	825
2:Ашиглалт эрхэлсэн зааварлагч	3	530	1590
Дүн	4	-	2415